



ӨСВӨР ҮЕ ХҮНС ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Баримт нягтлан шалгах комиссын
бүрэлдээхүүн, дүрмийг шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь заалт, Байгууллагын архивын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын архивын баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, хадгалах хугацааг тодорхойлох, хөтлөх нэрийн жагсаалтыг хянан хэлэлцэх, байнгын хадгалалтад баримтыг сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах эрх үүрэг бүхий "Баримт нягтлан шалгах комисс" (орон тооны бус)-ыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга

Менежер

Гишүүн

Ерөнхий нягтлан бодогч

Нарийн бичгийн дарга:

Архив, бичиг хэргийн ажилтан

2. Байгууллагын баримт нягтлан шалгах комиссын дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан байгууллагын "Баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн, дүрэм журам шинэчлэн батлах тухай" Захирлын 2017 оны А/40 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Дүрмийг комиссын гишүүд, нийт ажилтнуудад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг комисс (Б.Зоригоо)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Г.МӨНХЗУЛ

3130600053